

## ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийн тухай

### I. Гадаад худалдааны нөхцөл байдал

Монгол Улсын нийт бараа эргэлтийн дийлэнх хувийг хөрш орнууд болох Бүгд Найрамдах Хятад Ард Улс (цаашид "БНХАУ" гэх), Оросын Холбооны Улс (цаашид "ОХУ" гэх) эзэлж байгаа бөгөөд нийт экспортын дийлэнхийг БНХАУ-д экспортолж байна.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо (цаашид "ЕАЭЗХ" гэх)-ны гишүүн 5 орон хоорондын худалдааг авч үзвэл 2024 оны байдлаар нийт бараа эргэлт 3.0 тэрбум ам.доллар, үүнээс экспорт 110 сая ам.доллар, импорт 2.9 тэрбум ам.доллар буюу худалдааны алдагдал 2.8 тэрбум ам.доллар, худалдааны харьцаа 96:4 байна.

Манай улс 444 нэр төрлийн бараа экспортолсноос хайлуур жонш (44%), биологийн идэвхт хүнсний нэмэлт бүтээгдэхүүн (13%), ноос, ноолууран эдлэл, хивс (5%), муур, нохойн хоол (0.4%), цагаан архи (0.4%) голлон экспортолсон бөгөөд экспортын барааны нэр төрөл, тоо хэмжээ маш бага байна.

Харин ЕАЭЗХ-оос нийт 1916 нэр төрлийн бараа импортолсноос нефтийн бүтээгдэхүүн (71.3%), азотын бордоо (2.4%), цахилгаан эрчим хүч (2.4%), талх, амтлаг гурилан зүйлс (1.1%), гангаар хийсэн бусад цулдан, туйван (1.1%), вагон (1.1%), нефтийн кокс битум (1.0%), шоколад (1.0%) ихэвчлэн импортолсон ба нийт импортын мөнгөн дүнгийн 81.6 хувийг дээрх бүтээгдэхүүн эзэлж байна.

Үүнээс гадна Монголын гадаад худалдаа эрхлэгч, аж ахуйн нэгжүүд ЕАЭЗХ-ны гишүүн орнууд руу экспорт хийхэд дараах худалдааны хүндрэлүүд нийтлэг тохиолдож байна. Үүнд:

1. ЕАЭЗХ-ны хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний импортын татвар 15-50 хувь;
2. ОХУ-ын махны импортын квоттой;
3. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний техникийн зохицуулалтын шаардлага өндөр;
4. Гаалийн үйл ажиллагаа хүндрэлтэй, хүнд сурталтай;
5. Дамжин өнгөрөх тээвэрлэлтийн саатал, сав, баглаа боодлын асуудал;
6. ОХУ-ын тохирлын гэрчилгээ авахаар 4-6 сар хүлээгддэг, хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа 1 жил зэрэг болно.

### II. Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан байдал

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 4.4-т "Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө ... I үе шат (2021-2030): Хөрш орнуудыг дамжсан эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, бүс нутгийн эдийн засаг, худалдааны

интеграцад нэгдэх замаар эдийн засгийн гадаад харилцааг эрс нэмэгдүүлэх үе" гэж заасан.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.5.1-д "Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна", 3.2.5.3-т "Нэг орноос худалдан авах бараа бүтээгдэхүүн нийт импортод хэт давамгайлахаас сэргийлэх бодлого баримтална...", 3.2.5.4-т "Бус нутгийн болон олон улсын интеграцид нэгдэх, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг эдийн засгийн аюулгүй байдал, хөгжлийн шаардлагыг харгалзан, судалгаа, тооцоонд тулгуурлан, шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлнэ" гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.2.11-д "Бугд Найрамдах Солонгос Улс болон Евро-Азийн эдийн засгийн холбоо, Бугд Найрамдах Хятад Ард Улстай эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулж, худалдааны түвш улс орнуудтай хамтран ажиллах эдийн засгийн чиглэлийг нарийвчлан тодорхойлж, хөрөнгө оруулалт, экспорт, бизнесийг дэмжсэн харилцааг хөгжүүлнэ" гэж заасан.

Монгол Улс нь зөвхөн Япон Улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг байгуулсан. Мөн Ази, номхон далайн худалдааны хэлэлцээр, Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээрийг соёрхон баталсан. Олон улсын хэмжээнд чөлөөт худалдааны гэрээ байгуулсан орны үзүүлэлтээр Монгол Улс хамгийн цөөн тооны гэрээ байгуулсан орны тоонд багтаж байна. Далайд гарцгүй, 2 улстай хиллэдэг газарзүйн байршилтай, уул уурхайн бүтээгдэхүүний үнээс хамаарсан зах зээлтэй, гадаадын хөрөнгө оруулалт бага эдийн засагтай орны хувьд бус нутгийн интеграцийг гүнзгийрүүлэх нь чухал ач холбогдолтой.

### **III. Худалдааны түр хэлэлцээрийн төслийн тухай ерөнхий мэдээлэл**

#### **Хамрах хүрээ:**

Хэлэлцээрийн төсөл нь нийт 31 зүйл, 4 хавсралтаас бүрдэнэ. Үүнд: Барааны ангилал, Гаалийн татварын хөнгөлөлт болон/эсхүл чөлөөлөлт, Гарал үүслийн дүрэм, Гаалийн байгууллага ба худалдааг хөнгөвчлөх, Гаалийн хамтын ажиллагаа, Чөлөөтэй дамжин өнгөрөх, Амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ, Төлбөрийн тэнцлийг хангах зорилгоор хэрэгжүүлэх хязгаарлалт, Худалдааны хохирлыг арилгах арга хэмжээ, Ил тод байдал болон мэдээлэл солилцох, Цахим худалдаа, Эдийн засгийн хамтын ажиллагаа, Хамтарсан хороо зэрэг багтаж байна.

Хэлэлцээрт хөрөнгө оруулалт, үйлчилгээний худалдаа, банк санхүү, төлбөр тооцоо зэрэг асуудлууд тусгагдаагүй бөгөөд зөвхөн барааны худалдааны хүрээнд байгуулахаар тохиролцсон.

Хэлэлцээрийг 3 жилийн хугацаатай байгуулах бөгөөд талууд харилцан тохиролцон тус хугацааг сунгах боломжтой.

#### **Тарифын хөнгөлөлт эдлүүлэх нөхцөл:**

Энэхүү хэлэлцээрээр Монгол Улсаас гаралтай нийт 367 мөр бараанд хамаарах нийт 621 нэр төрлийн бараа, ЕАЭЗХ-ны гишүүн орнуудаас гаралтай нийт 367 мөр

бараанд хамаарах нийт 499 нэр төрлийн барааны гаалийн тарифын хувь хэмжээг тохиролцсон.

Талууд дараах байдлаар харилцан нөгөө талдаа тарифын хөнгөлөлт эдлүүлнэ.

Монголын тарифын үүрэг		ЕАЭЗХ-ны тарифын үүрэг	
Нөхцөл	Хамаарах барааны тоо /6 оронтой мөр бараа/	Нөхцөл	Хамаарах барааны тоо /6 оронтой мөр бараа/
Гаалийн тарифыг шууд тэглэх	356	Гаалийн тарифыг шууд тэглэх	365
Тарифыг бууруулах (25, 50 хувиар бууруулах)	6	Татварын бууралт хийх (25 хувиар бууруулах)	2
Квот тогтоож, заасан хэмжээнд тарифыг тэглэх	2		
Квот тогтоож, заасан хэмжээнд тарифыг бууруулах	3		

Монгол Улсаас ЕАЭЗХ-ны гишүүн орнуудад экспортлох нийт 621 нэр төрлийн бараанаас 619 барааны гаалийн тарифыг тэглэж, цагаан архи, шар айргийн тарифыг 25 хувиар бууруулна. Өөрөөр хэлбэл, манай улсын экспортын тэргүүлэх ач холбогдол бүхий бараанууд татваргүй экспорт хийх боломжтой. Жишээлбэл, үхрийн махны 50%, адгууны махны 15%, махан бүтээгдэхүүний 15-20%, ноос, ноолуурын 5-10%, нэхмэл, оёмол эдлэлийн 18%-ийн гаалийн тариф энэхүү хэлэлцээрийн хүрээнд татваргүй болж байна.

Үүнийг 2023 онд ОХУ-руу гаргасан экспортын гүйцэтгэлээр тооцож үзвэл Монгол Улсын аж ахуйн нэгжүүд 1 жилд багадаа 16.6 сая ам.доллартай тэнцэх гаалийн тарифыг тэглүүлэх бөгөөд хэлэлцээрийн хүрэх үр дүн, ач холбогдол нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдтэй нийтгэй болно.

Манай улсын стратегийн хүнсний бүтээгдэхүүн болох улаанбуудай болон өндөгний хувьд дотоодын үйлдвэрлэл, хэрэглээний хэмжээг харгалзан дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор квот тогтоож, тарифыг тэглэхгүйгээр бууруулах байдлаар тохирсон.

Сүүлийн 3 жилийн өндөгний дотоодын нийт хэрэглээ 448.6 сая ширхэг бөгөөд үүнээс 165 сая ширхэг буюу 36.8 хувийг импортоор нийлүүлсэн. Дотоодын өндөг үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор нийт зах зээлийн 20 хувийг импортын орон зайд хэвээр үлдээж, 90 сая ширхэг хүртэлх импортын өндөгт татварыг 50 хувь бууруулж 7.5 хувийн татвартай байх, 90 саяаас дээш импортолсон тохиолдолд татварыг хэвээр үлдээх буюу 15 хувийн татвартай байхаар тохиролцсон.

Мөн жил бүр ургац хураалтын нөхцөл байдлаас хамааран 30.0-50.0 мянган тонн улаанбуудайг импортлох шаардлага үүсдэг. Энэ хүрээнд айлын талаас хатуу болон зээлөн улаанбуудайд нийтдээ 180.0 мянган тоннын квот санал болгосныг 50.0 мянган тонн болгон бууруулж, айлын талыг буулт хийлгэснээр талууд тохиролцоонд хүрээд байна.

Ийнхүү Монгол Улсаас экспортлох бүтээгдэхүүний гаалийн тарифыг тэглэснээр тухайн барааг үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн орлого нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбарын шинэ зах зээлд нэвтрэх боломж бүрдэж, дотоодын бизнес эрхлэгчдийн гадаад худалдааны туршлага, чадвар нэмэгдэж, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд түлхэц болно. Тухайлбал:

- 9 нэр төрлийн мах, махан бүтээгдэхүүн татвартай экспортолж байгаа бол 29 болж нэмэгдэн, татвар тэглэгдэнэ;
- 24 нэр төрлийн арьс ширэн бүтээгдэхүүн татвартай экспортолж байгаа бол 60 болж нэмэгдэн, татвар тэглэгдэнэ;
- 64 нэр төрлийн ноос, ноолууран бүтээгдэхүүн татвартай экспортолж байгаа бол 204 болж нэмэгдэн, татвар тэглэгдэнэ;
- 22 нэр төрлийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн татвартай экспортолж байгаа бол 73 болж нэмэгдэн, татвар тэглэгдэнэ.

#### **Худалдааг хөнгөвчлөх зохицуулалт:**

Хэлэлцээрийн төсөлд худалдааг хөнгөвчлөх болон гадаад худалдаа эрхлэгчдэд давуу байдал үүсгэх дараах зохицуулалт тусгагдсан:

- Гарал үүслийг илүү таатай, уян хатан байдлаар тодорхойлох нөхцөлийг тусгасан. Тухайлбал, ЕАЭЗХ-ны гишүүн орнуудаас гаралтай түүхий эд, материалыг ашиглан Монгол Улсад боловсруулсан барааг Монгол Улсын гарал үүсэлтэйд тооцох боломжийг олгосон. Мөн тухайн барааны гарал үүслийн хувь 50 ба түүнээс дээш байхад гарал үүслийг хүлээн зөвшөөрөх, зарим тохиолдолд гарал үүсэлгүй материалыг ашиглах боломжийг нээж өгсөн. Барааг тээвэрлэхэд зориулсан сав, баглаа боодол, хайрцаг зэргийг тухайн барааны гарал үүслийг тогтооход тооцохгүй байх;
- Бараа бүтээгдэхүүнийг гаальд мэдүүлснээс хойш 4 цагийн дотор олгоно;
- Гаалийн мэдээлэл, гарал үүслийн гэрчилгээг цахимаар солилцох боломжтой;
- Гаалийн хяналт шалгалтын тухайд өндөр эрсдэлтэй бараанд шалгалтыг төвлөрүүлж, бага эрсдэлтэй бараанд хялбарчилна;
- Талууд итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хетөлбөр хэрэгжүүлнэ. Энэхүү хетөлбөрийг хэрэгжүүлснээр тухайн аж ахуйн нэгж бараагаа гаалийн байгууллагад байнга шалгуулах шаардлагагүй болох ба гаалийн бүрдүүлэлтэд шаардлагатай баримт бичгийн тоо, гаалийн бүрдүүлэлтийн хугацаа, зардал болон ачаа saat алт багасах зэрэг боломж бүрдэнэ;
- 5000 еврогоос доош үнийн дүн бүхий барааны гарал үүслийн гэрчилгээг экспортлогч заавал итгэмжлэгдсэн байгууллагаас буюу Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим (цаашид "MYXAYT" гэх)-аас авахгүйгээр өөрөө гаргаж болно. Энэ нь барааны нэхэмжлэх, гэрээ зэрэг хэлбэртэй байх боломжтой;

- Гарал үүслийн гэрчилгээг гаалийн мэдүүлгийг бүртгэсэн өдрөөс хойш 12 сарын дотор нөхөн гаргаж тарифын хөнгөлөлт эдлэх боломжтой;
- Талууд тохирлын үнэлгээний үр дүнг харилцан зөвшөөрөх гэрээ байгуулах хэлэлцээ эхлүүлж болно;
- Цахим худалдаа эрхлэгчдийн гаалийн бүрдүүлэлтийг хөнгөвчилнө;
- Цахим гарын үсэг нь цаасан хэлбэрийн гарын үсэгтэй адил эрх зүйн хүчинтэй байна;
- Монгол Улсаас ЕАЭЗХ-д экспортлох бараанд үндэсний нөхцөл олгож байгаа буюу тухайн улсын дотоодод үйлчлэх татвар, хураамжтай ижил хэмжээний татвар ногдуулах, дотоодын бараатай ижил дүрэм, журам, шаардлага тавигдах боломж бүрдсэн;
- Худалдаанд шаардлагагүй саад тогтор үүсгэсэн тохиолдолд Талууд Хамтарсан хорооны түвшинд техникийн зөвлөлдөх уулзалт хийн асуудлыг шийдвэрлэх нөхцөл бүрдсэн. Мөн хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн экспортлох үеийн эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагыг хялбаршуулах, тохирлын гэрчилгээний үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээг эхлүүлэх боломж бүрдэнэ.

#### IV. Хэлэлцээний явц

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд (хуучнаар) анх 2022 оны 11 дүгээр сард ОХУ-ын Москва хотноо зохион байгуулагдсан Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 24 дүгээр хуралдаанаар хоёр орны худалдааны тэнцвэргүй байдал, тарифын саад тогторыг асуудлыг хөндсөн бөгөөд талууд энэхүү нөхцөл байдлыг сайжруулахад хамтран ажиллахаар тохирсон.

Улмаар тус улсын Владивосток хотноо 2023 оны 09 дүгээр сард зохион байгуулагдсан Алс Дорнодын эдийн засгийн форумын үеэр ОХУ-ын Засгийн газрын орлогч дарга чөлөөт худалдааны түр хэлэлцээр эхлүүлэх ажил санал болгож, албан ёсны яриа хэлэлцээ эхлэх суурь нөхцөл бүрдсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд талууд дараах байдлаар хэлэлцээ, уулзалтыг зохион байгуулав. Үүнд:

1. Анхдугаар зөвлөлдөх уулзалт, 2024.01.28, Монгол Улс, Улаанбаатар хот;
2. Хоёрдугаар зөвлөлдөх уулзалт, 2024.03.13, ОХУ, Москва хот;
3. Эхний шатны хэлэлцээ, 2024.07.02, Монгол Улс, Улаанбаатар хот;
4. Хоёр дахь шатны хэлэлцээ, 2024.09.05, ОХУ, Москва хот;
5. Гурав дахь шатны хэлэлцээ, 2025.03.20, ОХУ, Москва хот.

#### V. Олон нийтийн хэлэлцүүлэг

Гаалийн татвараас чөлөөлөх барааны жагсаалтын талаар үйлдвэрлэл, гадаад худалдаа эрхлэгчдийн санал, байр суурийг нэгтгэх зорилгоор MYXAYT-тай хамтран 2023.12.13 болон 2024.05.09-ний өдрүүдэд хоёр удаагийн төр, хувийн хэвшлийн 150 гаруй төлөөлөл оролцсон хэлэлцүүлгийг зохион байгуулж, гарсан санал, хүсэлтүүдийг айлын талтай хийсэн албан ёсны хэлэлцээний үеэр тавьж, зөвшөөрсөн саналуудыг хэлэлцээрийн төсөлд тусгасан болно.

Мөн Засгийн газрын 2024.12.18-ны өдрийн хуралдааны 44 дүгээр тэмдэглэлээр өгсөн чиглэлийн дагуу "Хүнсний хувьсгал", "Цагаан алт", "Шинэ хоршоо хөдөлгөөн", "Атрын-IV тариалангийн тогтвортой хөгжлийн аян" зэрэг хөдөө аж ахуйн салбарын хөтөлбөрийн оролцогч талуудтай 2025.01.07-2025.01.10-ны

өдрүүдэд хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт нийт 61 аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоодын төлөөлөл оролцсон болно.

## VI. Холбогдох судалгаа

Хэлэлцээрийн эдийн засгийн нөлөөллийн шинжилгээг Дэлхийн худалдааны шинжилгээний төсөл (Global trade analysis project, цаашид "GTAP" гэх)-ийн ерөнхий тэнцвэрийн загварын хамгийн сүүлийн буюу 2023 оны 11С дата загвар ашиглан хийсэн. GTAP загвар нь олон улсын худалдаа, үйлдвэрлэл, эдийн засгийн бодлого, тэдгээрийн үр нөлөөг шинжлэхэд ашигладаг, дэлхийн 141 улс, 19 бүс нутгийн улс хоорондын худалдаа, тээвэр, тарифын хамгаалалт зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан, тоон мэдээллийн загвар болно.

Энэхүү хэлэлцээрээр Монгол Улс болон ЕАЭЗХ хоёр талаас ижил тооны буюу БТКУС-ын 6 оронтой кодоор 367 мөр бараанд тарифыг шууд тэглэх, тохирсон квотын хэмжээнд тарифыг тэглэх болон тохирсон квотын хэмжээнд тарифын хөнгөлөлт эдлэх гэсэн үндсэн 3 төрлөөр тарифын саад тогторыг бууруулахаар тохиролцсон.

Монгол Улсын хувьд 367 мөр барааны хүрээнд үндэсний кодын түвшинд нийт 621 нэр төрлийн бараанд татварын хөнгөлөлт эдлэх бол ЕАЭЗХ-ны хувьд 367 мөр барааны хүрээнд 499 нэр төрлийн бараанд татварын хөнгөлөлт эдлэхээр байна.

Хэлэлцээрийн үр дүнд архи, шар айрганаас бусад хэлэлцээрт хамрах барааны татварыг 0 хувь болгосноор манай улсын үндэсний үйлдвэрлэгчид ЕАЭЗХ-ны зах зээлд үнийн өрсөлдөх чадвар 15-50 хувиар нэмэгдэж байна. Мөн үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд экспортлохтой холбоотой ЕАЭЗХ-ны тарифын бус хязгаарлалтыг хялбарчилж байгаа тул экспорт илүү нэмэгдэх боломжтой.

Монгол Улсын гол нэрийн барааны худалдааны түр хэлэлцээрийн талууд руу гаргах экспортын хэмжээ өндөр өсөлт үзүүлэхээр байна. Тухайлбал, ОХҮ-д экспортлох бусад мах, махан бүтээгдэхүүний хэмжээ 140%-ийн өсөлт үзүүлэх нь хамгийн өндөр өсөлттэй салбар байна. Мөн ОХҮ, Казахстанд экспортлох малын мах, дайвар бүтээгдэхүүний хэмжээ тус тус 125.0%, 113.0%, нэмхэл эдлэл тус тус 55.4%, 27%, савхин эдлэл тус тус 45.7%, 152.0% өсөх дүн гарав. Бусад уул уурхай, олборлолтын ОХҮ-д гаргах экспорт 17%, Беларуст гаргах экспорт 18.7% нэмэгдэхээр байна.

Макро эдийн засгийн үзүүлэлтийн хувьд богино хугацаанд дотоодын нийт бүтээгдэхүүн 0.02%-аар нэмэгдэх, худалдааны нөхцөл 0.09%-аар сайжрах ба хөрөнгө оруулалт 2.57%-аар өсөх тооцоололтой байна. Хөрөнгө оруулалтын өсөлтийн нөлөөгөөр уг хэлэлцээрийн эдийн засагт үзүүлэх эерэг нөлөө цаашид дунд, урт хугацаанд нэмэгдэнэ.

Малын мах, сүү, тарианы үр, улаанбуудай, гурил, ундны усыг импортлох тоо хэмжээний тухайд хэлэлцээрийн төслийн 8 дугаар эүйлд "Хориг, тооны хязгаарлалт болон түүнтэй адилтгах нөлөө бүхий арга хэмжээ"-ний талаар тусгасан бөгөөд Хүнсний тухай хуульд тухайн жилд импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоохоор заасан тул татвар тэглэх болон бууруулах нь сөрөг үр нөлөө үзүүлэхгүй болно. Өөрөөр хэлбэл,

импортлох барааны тоо хэмжээнд хязгаарлалт тогтоож байгаа тул тариф тэглэх нь тус бүтээгдэхүүний зах зээлд нөлөө үзүүлэхгүй.

Мөн дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учруулж магадгүй, эсхүл учруулж байгаа тохиолдолд импортын өсөлтийг зохицуулах зорилгоор 1994 оны тариф, худалдааны өрөнхий хэлэлцээрийн 19 дүгээр зүйл, Тодорхой бүтээгдэхүүнийг импортлоход авах шуурхай арга хэмжээнд тусгасан хамгаалалтын арга хэмжээг хэрэглэн дотоодын зах зээлийг хамгаалах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР